

АРДЫН БАГШ Д. ЧОЙЖАЛСҮРЭНГИЙН НЭРЭМЖИТ МОНГОЛ БИЧГИЙН УЛСЫН УРАЛДААН – 2017

Монгол бичиг бол хүн төрөлхтний бүтээсэн оюуны соёлын салшгүй нэгэн хэсэг бөгөөд энэхүү бичгээ монголчууд мянган жилийн тэртээгээс хэл аялгуундаа тохируулан хэрэглэж, улам төгөлдөржүүлэн, олон зүйл мэдлэг ухааны туурвил бүтээлийг бичиж үлдээжээ.

Монголын ард түмний оюуны соёлын нандин өв болсон монгол бичгээ хадгалан хамгаалж, эзэмшин хэрэглэх, хойч үедээ өвлүүлэх ариун үйлс нь Та бүхний хичээл зүтгэл идэвх санаачилгаас хамаарах тул 16 дэх жилдээ уламжлал болгон зохиож буй Ардын багш Д. Чойжалсүрэнгийн нэрэмжит “Монгол бичгийн улсын уралдаан - 2017”-д Та бүхнийг идэвхийлэн оролцож, мэдлэг чадвараа сорьж, удмын бичгийн соёлт монгол хүн гэдгээрээ бахархана гэдэгт итгэж байна.

Ангилал, төрөл:

1. Төрийн болон хувийн хэвшлийн ажилтан, албан хаагч
 - Зохион бичих чадвар
2. ЕБС-ийн мэргэжлийн багш
 - Сорилго
3. Их дээд сургууль, коллежийн оюутан
 - а. Мэргэжлийн
 - Зохион бичих чадвар
 - б. мэргэжлийн бус
 - Хөрвүүлэн бичих чадвар
4. Бүх нийтийн хүрээнд
 - Монгол бичгээр цахимд бичих чадвар

Уралдааны журам:

1. Төрийн болон хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчид “Эх хэл, монгол бичгээ төгс эзэмшихийн учир утга” хэмээх сэдвийн дагуу монгол бичгээр алдаагүй зөв, сайхан найруулгатай, хичээнгүй, 120-140 үгэнд багтаан зохион бичсэн байна. Бийр, хулсан ба төмөр үзэг гэх мэт аль ч хэрэгслээр бичсэн байж болно.
 - 2017 оны 4 дүгээр сарын 25-ны 17:00 цаг хүртэл МУИС-ийн хичээлийн II байрны 305 тоотод хүлээн авч, эцсийн дүнг гаргана.
 - Уралдааныг шалгаруулахдаа оролцогчийн бичсэн эхийн найруулга, монгол бичгийн зөв бичих дүрэм, бичгийн хэв маяг, уран чадварыг үндэс болгоно. Та бусдаар бичүүлэх зэрэг зохисгүй үйлдэл хийхгүй гэдэг нь лавтай итгэж байна.
 - Шагналт байрт шалгарах болзол хангасан хүмүүстэй уралдааны эцсийн дүн гарахаас өмнө холбоо барьж тодорхой хэмжээгээр нягтлах болно.
2. ЕБС-ийн мэргэжлийн багш үе үеийн монгол бичгийн дурсгал, олон янзын тиг хэлбэрийн эхийг уншиж хэрэглэх мэдлэг чадвар, монгол бичгээр зөв хичээнгүй бичих, үгийн бүтцээр задлах зэрэг мэргэжлийн ур чадвараар өрсөлдөнө.
3. Их, дээд сургуулийн оюутан (мэргэжлийн болон мэргэжлийн бус) ангилалд оролцогч зохион бичих болон даалгаварт ажил гүйцэтгэнэ.
4. Бүх нийтийн хүрээнд оролцогч нь монгол бичгийг цахим орчинд хэрэглэх чадвараар уралдана.

Бүртгэл:

4 сарын 13-25-нд 10:00-17:00 хүртэл МУИС-ийн хичээлийн II байр, 3-р давхарт
Утас: 88208537, 80805178
bayarsaikhan.enkhsuvd@gmail.com

ЕБС-ийн мэргэжлийн багш (сорилго), их дээд сургуулийн оюутан (мэргэжлийн болон мэргэжлийн бус) мөн цахимд бичих чадварын төрөлд оролцох хүмүүс 2017 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт МУИС-ийн хичээлийн II байрны 343 тоотод хүрэлцэн ирж, уралдаандаа оролцоно уу.

Шагналын сан:

Ангилал тус бүрт:

1. Тэргүүн байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал, бэлэг дурсгал
2. Дэд байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал, бэлэг дурсгал
3. Гутгаар байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал, бэлэг дурсгал
4. Шагналт байр: Өргөмжлөл, мөнгөн шагнал, бэлэг дурсгал

Шагналыг “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр” гардуулна.

***Жич:** Шагналт байрт шалгарсан оролцогчтой тусгайлан холбоо барих тул овог нэр, албан байгууллагын хаяг, сургууль, утасны дугаараа тодорхой бичнэ үү. Уралдааны дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, зохион байгуулагч байгууллагуудын цахим хуудсаар (www.num.edu.mn; www.ims-num.org) зарлана.*

Ерөнхий зохион байгуулагч:

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим
Монгол бичиг соёлын “Хос уянга” нэгдэл

Хамтран зохион байгуулагч:

МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэн

Үндэсний бичгээ хойч үедээ дамжуулан хүргэгч Та бүхнийг идэвхтэй оролцохыг уриалж байна!

2017 оны 4 дүгээр сарын 7